



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/07

Хужирт сум

Зарим арга хэмжээг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн “Зарим арга хэмжээг зохицуулах тухай” 14 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд билгийн тооллын ХҮII жарны “Сайжруулагч” хэмээх Усан бар жилийн Цагаан сарын нэгдсэн золголт зохион байгуулахыг хориглосугай.

2. Олон нийтийг хамарсан тэмцээн уралдаан, хурал цуглааныг танхимаар зохион байгуулахыг 2022 оны 02 дугаар сарын 20-ны өдрийг дуусталх хугацаанд хориглосугай.

3. Байгууллага доторх ковидын өвчлөлийн нөхцөл байдалтай уялдуулан албан хаагчдаа бүтэн бус цагаар болон цахимаар ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Сар шинийн золголтыг уламжлалт ёс заншлаа хүндэтгэн гэр бүлийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг иргэдэд уриалж, сурталчилан ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Дэмбэрэл), Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Х.Түмэнбаяр) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ